



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Чин гэгээн өргөө ӨЭМТ-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/169/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Г.Нандинжаргал  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargalq@audit.gov.mn](mailto:nandinjargalq@audit.gov.mn)

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 327734 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Санхүүгийн аудитын албаны аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн:  
Бэст фортуна аудит ХХК-ийн захирал: Ж.Оюунцэцэг  
Утас: 324338, 89116465, 98056465  
Цахим хаяг: [fortune2009audit@gmail.com](mailto:fortune2009audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026-03-13 № 196  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН  
ЧИН ГЭГЭЭН ӨРГӨӨ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА Ц.БОЛОРТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянгол дүүргийн Чин гэгээн өргөө ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар нийт 14.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар букуу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, нягтлан бодох бүртгэлийн олон улын стандарт болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэг иргэнээр тооцсон зардлын санхүүжилтээр 347.5 сая төгрөгийн, 4 төрлийн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 80.5 сая төгрөгийн, хүүхдийн шүдний санхүүжилтээр 21.4 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвөөс дархлаажуулалтын зардалд 10.8 сая төгрөгийн, Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газраас улаан бурханы эсрэг дархлаажуулалтын зардалд 2.5 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

C:\Users\inarangua\Desktop\Бичиг хэргийн 2025\2025-03-13\1426050905

1426050905

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх үйлчилгээ оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулж ажилласан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Баянгол дүүргийн Чин гэгээн өргөө ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47 дугаар захирамжаар 95.3 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 98.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэргэ 2026\2026\word\ywsan bichig Dugnell 2026.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,260,757.23	184,246.92
Дансны авлага	45,634,800.64	5,637,975.50
Татвар, НДШ - ийн авлага	-	-
Бусад авлага	-	-
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	7,302,922.40	20,258,696.50
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>59,198,480.27</b>	<b>26,080,918.92</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	51,440,707.13	118,693,649.58
Биет бус хөрөнгө	-	-
Газар	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>51,440,707.13</b>	<b>118,693,649.58</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>110,639,187.40</b>	<b>144,774,568.50</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	-	607,720.00
Цалингийн өглөг	-	-
Татварын өр	19,093,876.75	7,653,856.60
НДШ - ийн өглөг	-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>19,093,873.75</b>	<b>8,261,576.60</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
Урт хугацаат зээл	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>19,093,873.75</b>	<b>8,261,576.60</b>
<b>Эзэмшигчдийн өмч</b>		
Төрийн	-	-
Хувийн	20,000.00	4,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг	91,525,313.65	136,508,991.90
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>91,545,313.65</b>	<b>136,512,991.90</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>110,639,187.40</b>	<b>144,774,568.50</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>415,932,116.44</b>	<b>468,299,686.30</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	479,306,595.55
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>415,932,116.44</b>	<b>(11,006,909.25)</b>
Түрээсийн орлого	-	-
Хүүний орлого	-	-
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	59,574,587.50
Борлуулалт, маркетингийн зардал	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	337,620,736.49	-
Санхүүгийн зардал	-	-
Бусад зардал	-	3,600,000.00
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг ( алдагдал)	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>78,311,379.95</b>	<b>44,967,678.25</b>
Орлогын татварын зардал	-	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>78,311,379.95</b>	<b>44,967,678.25</b>
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>78,311,379.95</b>	<b>44,967,678.25</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүүний	-	-
Бусад олз (гарз)	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>78,311,379.95</b>	<b>44,967,678.25</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>	<b>415,932,116.44</b>	<b>513,626,511.44</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	415,932,116.44	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	473,595,088.44
Бусад мөнгөн орлого	-	40,031,423.00
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	<b>409,741,170.21</b>	<b>483,971,331.75</b>
Ажиллагчдад төлсөн	143,660,599.00	229,542,868.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	16,495,168.88	74,416,374.60
Бараа материал худалдан авахад төлсөн	57,071,954.96	101,293,664.00
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	5,889,480.00
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	-	25,655,815.15
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	192,513,447.37	47,173,130.00
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>6,190,946.23</b>	<b>29,655,179.69</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	<b>35,731,690.00</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	-	35,731,690.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(35,731,690.00)</b>
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>6,190,946.23</b>	<b>(6,076,510.31)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>69,811.00</b>	<b>6,260,757.23</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,260,757.23</b>	<b>184,246.92</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	-	<b>13,213,933.70</b>	<b>13,233,933.70</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-
Тайлант үеийн ашиг	-	-	78,311,379.95	78,311,379.95
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	-	<b>91,525,313.65</b>	<b>91,545,313.65</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	16,000.00	<b>16,000.00</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>20,000.00</b>	-	<b>91,541,313.65</b>	<b>91,561,313.65</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Өмчит гарсан өөрчлөлт	(16,000.00)	-	-	<b>(16,000.00)</b>
Тайлант үеийн ашиг	-	-	44,967,678.25	<b>44,967,678.25</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>4,000.00</b>	-	<b>136,508,991.90</b>	<b>136,512,991.90</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,567.4 мянган төгрөгийн зөрчил илэрч 127.4 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,440.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн залруулагдаагүй 13,567.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгөв.

### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эмч, мэргэжилтэн нарыг гадаад улсад аялуулах 13,440.0 мянган төгрөгийн төсвийг ӨЭМТ-ийн даргын 2025 оны № А/19 дүгээр тушаалаар баталж, “Цахим тээл хөгжил” ХХК-тай аялал жуулчлалын гэрээ байгуулж Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс зарцуулсан.	1	13,440.0			1	13,440.0		
Нийгмийн даатгалын тайланд ажилд томилогдсон тушаал шийдвэргүй 1 хүний цалинг 660.0 мянган төгрөгөөр тооцож, НДШ-ийг 127.4 мянган төгрөгөөр тайлагнасан байна.	1	127.4	1	127.4				
Ажилтнуудад хавсран ажилласны нэмэгдэл цалинг олгохдоо тухайн хавсран ажиллаж байгаа албан тушаалын цалингаас тогтоосон хувиар тооцож олгох ёстой байтал тухайн нэмэгдэл цалин авч байгаа ажилтны өөрийнх нь албан тушаалын үндсэн цалингаас тогтоосон хувиар олгосон ба бүтэц орон тоо баталсан тушаал, хавсран ажиллах орон тооны тушаалд үндсэн цалинг тодорхой заагаагүй.	1	0					1	0
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>13,567.4</b>	<b>1</b>	<b>127.4</b>	<b>1</b>	<b>13,440.0</b>	<b>1</b>	<b>0</b>

#### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шилэн дансны цахим хуудсанд зарлагын 13,440.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй байна. Шилэн дансны цахим хуудасны “Тухайн ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд гаргасан зардал /өссөн дүнгээр” багананд улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний зарцуулалтыг өссөн дүнгээр мэдээлээгүй зөвхөн нийт эх үүсвэрийг 100 хувь зарцуулсан мэтээр мэдээлсэн байна.	1	13,440.0					1	13,440.0
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>13,440.0</b>					<b>1</b>	<b>13,440.0</b>